

# ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Чулуунхороот сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2026/010/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Чойбалсан хот  
2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Б.Болортуул  
Утас: 7058-4203, Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)  
Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар  
Аудитын менежер: Д.Нармандах  
Утас: 7058-4207, Цахим хаяг: [narmandakhd@audit.gov.mn](mailto:narmandakhd@audit.gov.mn)  
Аудитор Б.Одхүү  
Утас: 70584207 Цахим хаяг: [odkhuu@audit.gov.mn](mailto:odkhuu@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-7
3. Аудитын илрүүлэлт .....	7
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	8

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг  
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
Утас: 7058-4203

2026.03.25 № 424

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Чулуунхороот сумын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх нэгтгэсэн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох 9.6 сая төгрөгийг дутуу шилжүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

#### Бусад асуудлын хэсэг

Чулуунхороот сумын 2025 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг сумын ИТХ-ын 2025 оны 12 сарын 14-ний өдрийн 7/08

2126050244

дугаар тогтоолоор “Хангалттай” гэж дүгнэсэн байна. Сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг 93.4 хувиар дүгнүүлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>612,832.84</b>	<b>760,373.34</b>
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	261,759.51	396,031.8
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	98,343.93	111,047.65
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	252,729.39	253,293.89
<b>5</b>	<b>1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>4,797,149.33</b>	<b>4,870,218.14</b>
<b>6</b>	<b>1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>12а, 12б, 12в</b>	<b>4,797,149.33</b>	<b>4,870,218.14</b>
7	1.2.2.02 Биет хөрөнгө		4,714,161.59	4,787,595.14
8	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	82,987.74	82,623
<b>9</b>	<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>5,409,982.17</b>	<b>5,630,591.48</b>
<b>10</b>	<b>2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>62.7</b>	<b>185,389.67</b>
11	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		62.7	185,389.67
12	2.1.1.03 Өглөг		62.7	185,389.67
<b>13</b>	<b>2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>5,409,919.47</b>	<b>5,445,201.81</b>
14	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		5,409,919.47	5,445,201.81
15	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		637,383.46	637,383.46
16	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		4,477,276.76	4,512,559.1
17	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		295,259.25	295,259.25
<b>18</b>	<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>5,409,982.17</b>	<b>5,630,591.48</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>		<b>2,633,258.61</b>	<b>2,524,904.76</b>
<b>2</b>	<b>1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>411,945.62</b>	<b>488,318.3</b>
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		326,422.8	395,703.18
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		60,621.42	67,241.16
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		24,901.4	25,373.96
<b>8</b>	<b>1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1а, 1б</b>	<b>470,677.67</b>	<b>2,036,586.46</b>
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0	1,183,314.34
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,750,635.33	0
<b>11</b>	<b>1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2а, 2б</b>	<b>1,909,757.32</b>	<b>2,003,882.56</b>
<b>12</b>	<b>1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>1,909,757.32</b>	<b>1,979,932.56</b>
<b>13</b>	<b>1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>1,842,709.03</b>	<b>1,970,912.56</b>
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		778,448.91	879,737.31
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		99,167.34	108,216.25
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		492,514.17	532,821.29
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		66,634.24	89,910.53
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		12,347.9	4,394.9
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		14,241.2	18,712.6
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		44,449.89	36,580

**ДОРНОД АЙМГИЙН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ ЧУЛУУНХОРООТ СУМЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН  
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		334,905.38	300,539.69
<b>22</b>	<b>1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>67,048.29</b>	<b>9,020</b>
23	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0	23,950
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		723,501.3	521,022.19
25	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		596,260.89	471,457.85
26	<b>1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>		<b>-596,260.89</b>	<b>-471,457.85</b>
27	<b>1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>		<b>127,240.41</b>	<b>49,564.34</b>

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,243,070.87</b>	<b>2,146,093.8</b>
<b>2</b>	<b>1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>411,945.62</b>	<b>488,318.3</b>
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	326,422.8	395,703.18
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-34,219.27	-35,000
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	60,621.42	67,241.16
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	24,901.4	25,373.96
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,378.68	663.06
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	23,522.72	24,710.9
<b>9</b>	<b>1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>80,489.93</b>	<b>1,657,775.5</b>
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	80,489.93	100,922.38
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0	1,183,314.34
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	373,538.78
<b>13</b>	<b>1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,750,635.33</b>	<b>0</b>
<b>14</b>	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,602,821.69</b>	<b>1,673,579.48</b>
<b>15</b>	<b>1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,602,821.69</b>	<b>1,673,579.48</b>
<b>16</b>	<b>1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,535,773.4</b>	<b>1,664,559.48</b>
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	787,544.6	879,040.81
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,869.92	108,278.95
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	493,534.89	528,222.87
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	48,252.21	62,885.97
21	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	16,992.9	6,724.4
22	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	14,241.2	18,712.6
23	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,768.41	26,737.17
24	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	62,569.27	33,956.71
<b>25</b>	<b>1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>67,048.29</b>	<b>9,020</b>
<b>26</b>	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>640,249.18</b>	<b>472,514.32</b>
27	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	676,359.98	338,242.03
28	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	676,359.98	338,242.03
29	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	676,359.98	338,242.03
30	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-676,359.98	-338,242.03
<b>31</b>	<b>1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-36,110.8</b>	<b>134,272.29</b>
32	1.2 Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	297,870.31	261,759.51
33	1 Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	261,759.51	396,031.8

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн /мянган төгрөг/**

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,282,004.12		5,282,004.12
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	674.93		674.93
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,282,679.06		5,282,679.06
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	127,240.41		127,240.41
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,409,919.47		5,409,919.47
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,409,919.47		5,409,919.47
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-14,282		-14,282
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,395,637.47		5,395,637.47
9	1.7 Тайлант үеийн үр дүн	49,564.34		49,564.34
10	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,445,201.81		5,445,201.81

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/**

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,253,790.7</b>	<b>1,947,661.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,654,478.6</b>	<b>1,947,661.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,645,458.6</b>	<b>1,603,419.0</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	882,044.6	861,670.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,457.0	104,215.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	527,506.2	525,794.7
2104	Хангамж, бараа материалын зардал	58,481.8	47,107.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,407.7	6,724.4
2107	Төмилөлт, зочны зардал	19,565.0	18,712.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,984.0	3,370.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,012.3	26,804.3
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,020.0</b>	<b>9,020.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,020.0	9,020.0
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>494,312.1</b>	<b>344,242.00</b>
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>105,000.0</b>	<b>0</b>
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,253,790.7</b>	<b>2,042,705.1</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>-</b>	<b>-</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,025,162.2</b>	<b>2,042,705.1</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,642,045.5	1,669,166.3
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	383,116.7	373,538.8
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>228,628.5</b>	<b>-</b>
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	228,628.5	
4	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	261,016.4
5	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	396,011.1

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,748.8</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,748.8</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,748.8
2104	Хангамж, бараа материалын зардал	2,596.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,152.4
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>9,748.8</b>
	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,748.8</b>

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 572.4 сая төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрсэнд 2 зөвлөмж өглөө.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд илэрсэн алдаа, зөрчлөөс 22.8 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5.4 сая төгрөгөөр дутуу байгаа тул *Өөрчлөлтгүй* дүгнэлт өглөө.

### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн орлогын гүйцэтгэлтэй холбоотой асуудал:

*Илрүүлэлт:* Орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 28.3 сая төгрөг буюу 0.8 хувиар давж биелсэн байна. Үүнд татварын орлого 26.8 сая төгрөгөөр, татварын бус орлого 1.4 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл үл хөдлөх хөрөнгийн албан татвар 1.2 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 0.3 сая төгрөгөөр, газрын төлбөр 10.3 сая төгрөгөөр нийт 11.8 сая төгрөгөөр тасарсан байна.

*Өгсөн зөвлөмж:* Орлогыг нэр төрлөөр нь бүрэн төвлөрүүлж ажиллах.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

*Илрүүлэлт:* Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Shilendans.gov.mn цахим хуудсанд батлагдсан төсөв, гүйцэтгэл, хөтөлбөр зориулалт, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, дараа жилийн төсвийн төсөл зэрэг 560,564.1 сая төгрөгийн 6 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

*Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулсан байх.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлэх, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган  
төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
үл хөдлөх хөрөнгийн албан татвар 1.2 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 0.3 сая төгрөгөөр, газрын төлбөр 10.3 сая төгрөгөөр нийт 11.8 сая төгрөгөөр тасарсан	1	11,831.9	-	-	-	-	1	11,831.9	-	-	-	-
Дүн	1	11,831.9	-	-	-	-	1	11,831.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулах 178 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.	1	560,564.1	-	-	-	-	1	560,564.1
Дүн	1	560,564.1					1	560,564.1
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								